



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн  
үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ХК-ийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 498,316,373 /дөрвөн зуун ерэн найман сая гурван зуун арван зургаан мянга гурван зуун далан гурав/ ширхэг энгийн хувьцааг хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдүүлсэнтэй холбогдуулан 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,781,861,267 /нэг тэрбум долоон зуун наян нэгэн сая найман зуун жаран нэгэн мянга хоёр зуун жаран долоо/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж нийт 2,280,177,640 /хоёр тэрбум хоёр зуун наян сая нэг зуун далан долоон мянга зургаан зуун дөч/ ширхэг хувьцаатай байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөн бүртгэхийг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/, Хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ХК /Ж.Равдандорж/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000612